



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14.2.10 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Үндэсний оношлогоо эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төслийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг 2015 оны 9 дүгээр сард багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081041

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08 сарын 10-ны өдрийн  
...302 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Үндэсний оношлогоо  
эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх  
ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

**Ажлын хэсгийн дарга:** Э.Оюунсүрэн, ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ,  
үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

**Нарийн бичгийн дарга:** Г.Туул ЭМСЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ,  
дотоод аудитын газрын мэргэжилтэн

**Гишүүд:** Г.Базархүрэл, ЭМСЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ,  
дотоод аудитын газрын мэргэжилтэн

Б.Чулуунбат, ЭМСЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод  
аудитын газрын мэргэжилтэн

Н.Энхбат, ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын  
газрын мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 08 сарын 10-ны өдрийн  
...302 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Үндэсний оношлогоо  
эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагаанд дотоод аудит  
хийх ажлын удирдамж**

**Зорилго:** БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Үндэсний оношлогоо эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж боловсруулах,

**Дотоод аудитын ерөнхий чиглэл:** Дотоод аудитыг гүйцэтгэхдээ дараах хууль, тогтоомж, дүрэм журмыг ашиглана. Үүнд:

- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай Монгол улсын хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Худалдан авах ажиллагаатай холбоотой холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан журам, дүрэм
- Засгийн газрын 2012 оны 129 тоот тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”
- Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаал, 2014 оны 160 дугаар тушаал
- Улсын салбарын Дотоод аудитын гарын авлага
- Дотоод аудитын Мэргэжлийн практикийн олон улсын стандарт

**Ажиллах бүрэлдэхүүн:** Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын эмнэлгийн тусламжийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд

**Хамрах хүрээ:** БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Үндэсний оношлогоо эмчилгээний төв байгуулах төсөл

**Хугацаа:** 2015 оны 08 дугаар сарын 10-наас 14-ний хооронд

**Хүрэх үр дүн:** Дотоод аудитын тайланг ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулах,